

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Гэрчилгээ.....	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил.....	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	10
3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал.....	10
3.2. Зардлын данстай холбоотой асуудал.....	11
3.3. Зардлын данстай холбоотой асуудал.....	11
3.4. Зардлын данстай холбоотой асуудал.....	12
3.5. Шилэн данстай холбоотой асуудал	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1. Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан	13
4.2. Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан	14
4.3. Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4. Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5. Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19
4.6. Аудит хийсэн Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан.....	21
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
БСШУСЯ	Боловсрол, соёл шинжлэх ухааны яам



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЧОЙЖИН ЛАМЫН СҮМ МУЗЕЙН
ЗАХИРАЛ Д.ОТГОНСҮРЭН ТАНАА

2020.02.18 № 06/525
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Чойжин ламын сүм музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Чойжин ламын сүм музейн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Чойжин ламын сүм музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Чойжин ламын сүм музейн захирал Д.Отгонсүрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн зардлын дансны нягтлан бодох бүртгэл, тайлагналыг холбогдох стандарт дүрэм, журмын дагуу бүртгэх, үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлттэй холбоотой зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Чойжин ламын сүм музейн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Чойжин ламын сүм музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 25-аас 2020 оны 02 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг хоёр дахь шатны, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг анхан шатны хяналт хэрэгжүүлэхээр, ахлах аудитор Б.Цогзолмаа, аудиторын туслах Т.Алтанчимэг, Ш.Тэгш-Ерөөлт нар хариуцаж хэрэгжүүлэв.

Чойжин ламын сүм музей нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, аргазүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Чойжин ламын сүм музейн эрхэм зорилго нь Музейд хадгалагдаж буй Монголын түүх, шашин, соёл, уран барилга, урлахуйн ухааны дахин давтагдашгүй үнэт бүтээлийг судлан сурталчилж, сэргээн баяжуулах, хадгалан, хамгаалж, хойч үеийнхэнд уламжлуулахад оршино.

Музей нь нийт 6 сүмд Монголын түүх шашны холбогдолтой 6385 гаруй үзмэр, эд зүйлсийг дэлгэн үзүүлдэг ба жилд дунджаар 15,000 гаруй үзэгч үйлчлүүлэгчдийг хүлээн авдаг, 20 ажилтантай, эрдэм шинжилгээ, сан хөмрөгийн нэгж, захиргаа, аж ахуйн нэгж гэсэн 2 нэгжтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

2009 онд батлагдсан Улс, орон нутгийн музейн дүрмийн 1.2-д зааснаар Чойжин ламын сүм музейн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Музей, түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах үйл ажиллагаа;
- Музей нийгэмд үйлчилж, соён гэгээрүүлэх, сургах, таашаал хүртээх зорилгоор хүн түүний орчинтой холбоотой бодит ба бодит бус байгаль, соёлын өвийг цуглуулах, хадгалах, судлан шинжлэх, дэлгэн үзүүлэх, харилцан холбох байнгын үйл ажиллагаа бүхий ашгийн төлөө бус, олон нийтэд нээлттэй байгууллага байх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 тоот тогтоолоор “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”, “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам”, “Төрийн албан хаагчид докторын зэрэг, профессор цолны нэмэгдэл олгох журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам”, “Төрийн үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 5 тоот тогтоолоор “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”, “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан, хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох эрх бүхий албан тушаалтны жагсаалт”, “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолоор баталсан “Шинжлэх ухааны салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл”, “Төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын зэрэглэл”;
- “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоол”;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ыг Монгол Улсын Сангийн сайдын 2019 оны 74 дугаар тушаалаар баталсан.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан.

Тус музейн одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байгаа боловч тухайн байгууллагын гол хөрөнгө болох түүх соёлын үнэт зүйлийг хэрхэн бүртгэх, тайлагнах талаар бодлого, дүрэм журам тусгагдаагүй.

Чойжин ламын сүм музей нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “ACOLOUS 3.0” програм хангамж ашигладаг байна.

Чойжин ламын сүм музейн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Чойжин ламын сүм музейн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөлтийн үе шатанд 19 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны гуравдугаар улирлын санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 337,444.7 мянган төгрөгөөс тооцон 6,748.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож 7,860.0 мянган төгрөгөөр тооцсон нь музейн үйл ажиллагааны цар хүрээ, төсвийн санхүүжилтийн хэмжээ, үйл ажиллагааны орлого, зардал, эрсдэл бага байгаатай холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Чойжин ламын сүм музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 990,105.4 мянган төгрөгөөр буюу 24.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, урьдчилж гарсан зардал, бараа материал, биет хөрөнгө, биет бус хөрөнгө, засгийн газрын оруулсан капитал данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	19,534.5	3,753.7	-15,780.8
Урьдчилгаа		11,600.0	11,600.0
Бараа материал	34,983.8	45,045.2	10,061.4
Биет хөрөнгө	4,030,937.9	4,357,562.6	326,624.7
Биет бус хөрөнгө		657,600.0	657,600.0
Нийт хөрөнгө	4,085,456.2	5,075,561.5	990,105.3
Өр төлбөр			-

Засгийн газрын оруулсан капитал /засгийн газрын сан/	1,258,814.0	1,906,414.0	647,600.0
Хуримтлагдсан үр дүн	280,524.5	623,029.8	342,505.4
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,546,117.7	2,546,117.7	
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,085,456.2	5,075,561.5	990,105.3

Авлагын дансны үлдэгдэл 15,780.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны эхний үлдэгдэл 19,534.5 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулж, тайлант оны эцсийн байдлаар гэрэл, цахилгааны төлбөрийг 3,753.7 мянган төгрөгөөр илүү төлсөнтэй холбоотой.

Урьдчилж төлсөн зардал дансанд 11,600.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь хэвлэлийн компанид ном хэвлүүлэхээр гэрээ байгуулан урьдчилгаа төлбөрийг шилжүүлсэн, гэрээний хугацаа дуусаагүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 10,061.4 мянган төгрөгөөр өссөн нь Чойжин ламын сүм байгуулагдсаны 110 жил, музей болсны 80 жилийн ойг тохиолдуулан музейн үйл ажиллагаа, түүхийг сурталчлах зорилгоор ном тараах материал хэвлүүлсэнтэй холбоотой байна.

Биет хөрөнгө дансны үлдэгдэл 8.1 хувь буюу 326,624.7 мянган төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- “Өв эрдэнэ” төслийн хүрээнд 320,020.1 мянган төгрөгийн зам талбай, гэрэлтүүлгийн ажил хийгдсэн;
- Нэмэлт санхүүжилтийн данснаас 7,885.4 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шинээр худалдан авсан;
- Гаалийн байгууллагад хураагдсан түүх соёлын дурсгалт зүйл 6,600.0 мянган төгрөгийг хүлээн авсан;
- Тайлант онд 7,880.8 мянган төгрөгийн элэгдлийн зардал байгуулсан;
- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр анхны өртгөө элэгдлээрээ бүрэн нөхсөн 67,914.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг данснаас хасаж акталсантай холбоотой байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 657,600.0 мянган төгрөгөөр өссөн нь газар эзэмших эрх 647,600.0 мянган төгрөг, оюуны өмчийн хөрөнгө 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант онд 647,600.0 мянган төгрөгөөр өссөн нь газар эзэмших эрхийг бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга дансанд 7,411.6 мянган төгрөгийн бичилт хийгдсэн нь гэрэл, цахилгааны зардалд илүү төлсөн байгууллагаас авах авлагын эхний үлдэгдлийг санхүүгийн тайланд тусгаагүй байсныг аудитаар залруулж бүртгэсэнтэй холбоотой байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Чойжин ламын сүм музей тайлант онд 78,253.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн бөгөөд тус орлого нь төлөвлөгөөнд тусгаагаагүй байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 323,223.2 мянган төгрөгийг урсгал зардлыг улсын төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Тайлант онд тус музейд хэрэгжсэн “Өв эрдэнэ” төслөөр зам талбай, тохижилт хийгдэж 320,020.1 мянган төгрөг, гаалийн байгууллагаас хураагдаж ирүүлсэн 6,600.0 мянган төгрөгийн түүх соёлын үнэт зүйл нийт 326,020.1 мянган төгрөгийн үнэ төлбөргүй орлого хүлээн авсан.

Нэмэлт төсөв: Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон 78,253.0 мянган төгрөгийг Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам”-ыг үндэслэн нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулан 78,151.6 мянган төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж, 101.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 19 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 7 эрсдэл тодорхойлж нийт 26 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,244,759.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,242,082.3 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,677.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Аудитаар дараах 1,242,082.3 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

1. Багаж хэрэгслийн зардлын ангилалд 6,400.0 мянган төгрөгийн урсгал засварын зардлыг тайлагнасан;
2. Бараа материалын үлдэгдэлд 3 нэр төрлийн 2,792.3 мянган төгрөгийг зөрүүтэй илэрхийлсэн;
3. Эргэлтийн бус хөрөнгийн ангилалд тайлагнагдах музейн үйл ажиллагааг танилцуулсан 10,000.0 мянган төгрөгийн түүхэн баримтат киног бараа материалын дансанд бүртгэсэн;
4. “Өв эрдэнэ” төслийн хүрээнд зам талбай, усалгааны систем зэрэг 320,020.1 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хийж гүйцэтгүүлэн, хүлээн авсан боловч бүртгэлд тусгаагүй;
5. Гэрэл, цахилгааны зардлыг 3,657.9 мянган төгрөгөөр дутуу тусгаж, илүү төлсөн 3,753.7 мянган төгрөгийг авлагаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй;
6. Улсын төсвийн санхүүжилт 323,223.2 мянган төгрөгөөр батлагдсан байхад төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгахдаа 389,803.2 мянган төгрөгөөр тайлагнаж 66,580.0 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн;
7. Анхан шатны баримтгүйгээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга дансанд 3,000.0 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хааж бүртгэсэн;
8. Дахин үнэлгээгээр 647,600.0 мянган төгрөгөөр үнэлэгдсэн газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй;
9. Музейн үзмэр эд өлгийн ерөнхий бүртгэлийн дансанд бүртгэлтэй Гол ба Занхан сүмийн дээврийн сэргээн засварлалтын үнэ болох 178,278.3 мянган төгрөг бүхий засварын ажил БСШУЯ-ны хөрөнгө оруулалтаар үнэ төлбөргүй хийгдсэнийг бүртгэлд тусгаагүй.

Аудитаар илэрсэн 2,677.2 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дараагийн аудитаар тус музейн билетийн орлогын бүртгэл, тайлагнал болон үйл ажиллагааны орлогыг 2020 оны батлагдсан төсөвт тусгаагүй байгаа тул гол анхаарах асуудлаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Чойжин ламын сүм музей нь дэлхийн өнцөг булан бүрээс 250 дурсгалт газрууд өрсөлдсөнөөс 25 дурсгалт газрын нэгээр сонгогдсон нь гол онцлог үйл явдал болсон байна.

Америкийн нэгдсэн улсын дурсгалт уран барилгын сэргээн засварлалтын архитектор Стивен Келли нь "Өв Эрдэнэ" төслийн хүрээнд Чойжин ламын сүм музейн барилгын нөхцөл байдлын судалгааг хийж, хадгалалт хамгаалалтын менежмент төлөвлөгөөг олон улсын стандартын дагуу боловсруулж 320,020.1 мянган төгрөгийн сэргээн засварлалт хийж цаашид тус ажлыг үргэлжлүүлэхээр байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Чойжин ламын сүм музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 67 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 7 мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 647,600.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлснийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй. Үүнийг 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар залруулсан.

Нийт 3 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Чойжин ламын сүм музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Залруулагдаагүй 2,677.2 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 7,860.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй дүгнэлт өгч байна.

Чойжин ламын сүм музейн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Чойжин ламын сүм музей тайлант онд 78,253.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого бүрдүүлсэн бөгөөд тус орлого нь төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4-т "Энэ журмын 3.1.1-д заасан үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлого бүрдүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглоно", 3.4.3-т "Үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ", 6.4.1-т "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэсэн заалтуудтай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлгүй батлуулах, үргүй зардал гаргах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, дээд шатны байгууллагаар батлуулан, үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгахгүй орхигдуулсан зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2. Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Ажил гүйцэтгэх гэрээгээр 3,400.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосныг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй, цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийг буруу ангиллаар 1,029.7 мянган төгрөг тайлагнаснаас нийт 982.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн ногдол үүсгээгүй байна.

Энэ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-т Дараах хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогод нийгмийн даатгалын шимтгэл ногдуулна: 32.1.2-т “Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээгээр тохирсон хөлс” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Нийгмийн даатгалын тухай хуулийг мөрдөж ажиллахгүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу ажил гүйцэтгэх гэрээгээр хувь хүнд ажлын хөлс олгосон тохиолдолд нийгмийн даатгалын тайланд тусгах, даатгуулагчийн код буруу сонгосон 1 ажилтантай холбоотой цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд залруулга хийлгэх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Нийгмийн даатгалын хуулийн дагуу алдаагүй зөв бэлтгэн гаргаж ажиллана. 2020 онд алдааг залруулна.

3.3 Зардлын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Шатахууны зардлыг тооцохдоо жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жишиг нормын дагуу тооцоогүйгээс 481.1 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон.

Энэ нь Монгол улсын дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтад тусгагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-той нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрээгүй боловч Засгийн газраас тогтоосон өдөрт явбал зохих км, цилиндрийн багтаамжтай холбоотой норм нормативыг зөрчих;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Автомашин 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ын дагуу шатахууны тооцоог үнэн зөв тооцох

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тээвэр шатахууны тооцоог баталсан нормын дагуу бодон тооцож ажиллана.

3.4 Зардлын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Ээлжийн амралтын тооцоог давтан тооцоход 4 ажилтанд 179.6 мянган төгрөгийг илүү олгосон, 11 ажилтанд 1,213.3 мянган төгрөгийг дутуу олгосон.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.4-т “үнэн зөв байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Цалин хөлс, шагнал урамшуулал болон ээлжийн амралтын тооцоог илүү, дутуу тооцож олгосон байх;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Ээлжийн амралтын тооцоог холбогдох журмын дагуу үнэн зөв тооцож олгох

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Ээлжийн амралтын тооцоог журмын дагуу үнэн зөв тооцож ажиллана.

3.5 Шилэн данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Чойжин ламын сүм музей Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 67 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 7 мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ...” гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийг зөрчих;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг заасан хугацаанд байршуулах, зөрчлийг давтан гаргахгүй байх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийн хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН

4.1 Аудит хийсэн Санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>54,518,241.00</u>	<u>60,398,975.60</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	19,534,462.00	3,753,736.60
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	89,833.00	-
335	Бусад авлага	19,444,629.00	3,753,736.60
3351	Байгууллагаас авах авлага	19,444,629.00	3,753,736.60
34	УРЬДЧИЛГАА	-	11,600,000.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	11,600,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	34,983,779.00	45,045,239.00
354	Хангамжийн материал	34,983,779.00	45,045,239.00
35410	Бичиг хэргийн материал	7,837,150.00	18,088,955.00
35420	Аж ахуйн материал	12,409,468.00	13,520,818.00
35430	Сэлбэг хэрэгсэл	275,000.00	275,000.00
35470	Бусад хангамжийн материал	14,462,161.00	13,160,466.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,030,937,947.93</u>	<u>5,015,162,655.31</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,030,937,947.93	5,015,162,655.31
391	Газар	-	-
392	Биет хөрөнгө	4,030,937,947.93	4,357,562,655.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	27,462,751.44	301,521,218.50
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(554,873.52)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	230,694,654.33	195,265,673.33
39206	Хуримтлагдсан элэгдэл	(198,424,489.20)	(161,816,658.94)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	73,343,679.00	48,743,139.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,715,526.64)	(27,734,374.58)
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	3,947,692,959.00	3,954,292,959.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	45,961,652.52
39217	Ном	1,883,920.00	1,883,920.00
393	Биет бус хөрөнгө	-	657,600,000.00
39301	Програм хангамж	990,000.00	990,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(990,000.00)	(990,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	-	657,600,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,085,456,188.93</u>	<u>5,075,561,630.91</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,085,456,188.93</u>	<u>5,075,561,630.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,085,456,188.93	5,075,561,630.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,258,814,021.00	1,906,414,021.00
51101	Өмч: - төрийн	1,258,814,021.00	1,906,414,021.00
512	Хуримтлагдсан үр дүн	280,524,417.59	623,029,859.57
51210	Өмнөх үеийн үр дүн	280,524,417.59	287,936,042.19
51220	Тайлант үеийн үр дүн	-	335,093,817.38
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,546,117,750.34	2,546,117,750.34
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,085,456,188.93</u>	<u>5,075,561,630.91</u>

4.2 Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	373,517,350.00	906,374,673.58
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	80,758,050.00	504,898,473.58
120	Нийтлэг татварын бус орлого	80,758,050.00	504,898,473.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	80,758,050.00	504,898,473.58
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,316,500.00	-
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,441,550.00	504,898,473.58
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,759,300.00	401,476,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	231,353,800.00	323,223,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,353,800.00	323,223,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,405,500.00	78,253,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,380,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,025,500.00	77,253,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	358,011,466.44	571,280,856.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	358,011,466.44	571,280,856.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	352,099,567.44	567,626,342.20
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,031,682.00	204,807,018.00
210101	Үндсэн цалин	132,598,687.00	167,373,445.00
210102	Нэмэгдэл	-	30,421,673.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	7,011,900.00
210104	Урамшуулал	11,084,095.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,326,003.00	23,112,078.00
210201	Тэтгэврийн даатгал	12,217,333.00	17,383,501.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,527,168.00	1,432,144.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,221,734.00	1,145,715.00
210204	Ажилгүйдлийн даатгал	305,434.00	286,429.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,054,334.00	2,864,289.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,924,383.00	17,984,176.00
210301	Гэрэл, цахилгаан	9,630,000.00	15,595,888.00
210303	Цэвэр, бохир ус	1,294,383.00	2,388,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	9,315,400.00	11,125,521.00
210401	Бичиг хэрэг	786,400.00	5,730,250.00
210402	Тээвэр, шатахуун	2,992,900.00	2,992,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,346,874.00	261,921.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	173,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,189,226.00	1,966,650.00
2105	Нормативт зардал	-	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,041,900.00	203,067,354.00

Чойжин ламын сүм музейн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210601	Багаж, техник, хэрэгсэл	9,000.00	2,253,600.00
210602	Тавилга	-	20,000.00
210604	Урсгал засвар	5,032,900.00	200,793,754.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	12,351,654.00
210701	Гадаад албан томилолт	-	10,351,654.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	63,515,421.00	66,440,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,715,021.00	59,340,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,399,700.00	1,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	640,400.00	1,100,000.00
210807	Газрын төлбөр	1,760,000.00	4,200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,944,778.44	28,637,581.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	64,875,599.00	20,756,769.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25,069,179.44	7,880,812.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,911,899.00	3,654,514.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,911,899.00	1,654,514.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,911,899.00	1,654,514.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,505,883.56</u>	<u>335,093,817.38</u>
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	-	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,768,934.18	-
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	7,768,934.18	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(7,768,934.18)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>7,736,949.38</u>	<u>335,093,817.38</u>

4.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	372,075,800.00	401,476,200.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	79,316,500.00	-
120	Нийтлэг татварын бус орлого	79,316,500.00	-
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	79,316,500.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	79,316,500.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	292,759,300.00	401,476,200.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	231,353,800.00	323,223,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,353,800.00	323,223,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	61,405,500.00	78,253,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	25,380,000.00	1,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	36,025,500.00	77,253,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	348,681,600.00	393,590,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	348,681,600.00	393,590,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	342,769,701.00	389,936,286.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,121,514.00	201,878,299.00
210101	Үндсэн цалин	132,688,519.00	145,499,909.00
210102	Нэмэгдэл	-	36,430,490.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	9,348,900.00
210104	Урамшуулал	11,084,095.00	10,599,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	18,326,004.00	25,950,964.00
210201	Тэтгэврийн даатгал	12,217,334.00	20,991,306.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,527,168.00	881,878.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,221,734.00	1,851,218.00
210204	Ажилгүйдлийн даатгал	305,434.00	462,805.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,054,334.00	1,763,757.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,924,383.00	14,326,288.00
210301	Гэрэл, цахилгаан	9,630,000.00	11,938,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,294,383.00	2,388,288.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,545,900.00	10,184,121.00
210401	Бичиг хэрэг	1,266,900.00	4,134,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,992,900.00	2,992,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,346,874.00	261,921.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	173,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,939,226.00	2,621,000.00
2105	Нормативт зардал	7,260,000.00	100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,260,000.00	100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,041,900.00	25,289,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	2,253,600.00
210602	Тавилга	-	20,000.00
210604	Урсгал засвар	5,041,900.00	23,015,400.00
2107	Томилолт, зочны зардал	2,000,000.00	12,351,654.00
210701	Гадаад албан томилолт	-	10,351,654.00
210702	Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	99,524,500.00	99,855,960.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	91,594,500.00	90,455,960.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,399,700.00	1,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	750,000.00	1,100,000.00

210807	Газрын төлбөр	1,760,000.00	4,200,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,020,000.00	2,300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,025,500.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	36,025,500.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,911,899.00	3,654,514.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,911,899.00	1,654,514.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,911,899.00	1,654,514.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>23,394,200.00</u>	<u>7,885,400.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	23,394,200.00	7,885,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	23,394,200.00	7,885,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	23,394,200.00	7,885,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	23,394,200.00	7,885,400.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(23,394,200.00)</u>	<u>(7,885,400.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

4.4 Аудит хийсэн Цэвэр хөрөнгө/Өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/төгрөг/
				Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,258,814,021.00	2,536,201,022.00	272,787,468.21	4,067,802,511.21
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,258,814,021.00	2,536,201,022.00	272,787,468.21	4,067,802,511.21
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	9,916,728.34		9,916,728.34
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-			-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн			7,736,949.38	7,736,949.38
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,258,814,021.00	2,556,034,478.68	280,524,417.59	4,085,456,188.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	7,411,624.60	7,411,624.60
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,258,814,021.00	2,546,117,750.34	287,936,042.19	4,092,867,813.53
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	647,600,000.00	-	-	647,600,000.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
Тайлант үеийн үр дүн			335,093,817.38	335,093,817.38
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,906,414,021.00	2,546,117,750.34	623,029,859.57	5,075,561,630.91

4.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	323,223,200.00	321,670,032.00	1,553,168.00	99.52
УРСГАЛ ЗАРДАЛ	323,223,200.00	321,670,032.00	1,553,168.00	99.52
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	322,223,200.00	320,670,032.00	1,553,168.00	99.52
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	191,418,500.00	191,279,299.00	139,201.00	99.93
Үндсэн цалин	144,896,800.00	145,499,909.00	(603,109.00)	100.42
Нэмэгдэл	37,172,800.00	36,430,490.00	742,310.00	98.00
Унаа хоолны хөнгөлөлт	9,348,900.00	9,348,900.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,125,800.00	24,625,964.00	499,836.00	98.01
Тэтгэврийн даатгал	17,085,600.00	22,541,540.00	(5,455,940.00)	131.93
Тэтгэмжийн даатгал	2,010,100.00	652,280.00	1,357,820.00	32.45
ҮОМШӨ-ний даатгал	1,608,000.00	1,145,715.00	462,285.00	71.25
Ажилгүйдлийн даатгал	402,000.00	286,429.00	115,571.00	71.25
Эрүүл мэндийн даатгал	4,020,100.00	1,763,757.00	2,256,343.00	43.87
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,553,300.00	14,326,288.00	227,012.00	98.44
Гэрэл, цахилгаан	13,888,800.00	11,938,000.00	1,950,800.00	85.95
Цэвэр, бохир ус	664,500.00	2,388,288.00	(1,723,788.00)	359.41
Хангамж, бараа материалын зардал	10,184,700.00	10,184,121.00	579.00	99.99
Бичиг хэрэг	971,900.00	4,134,500.00	(3,162,600.00)	425.40
Тээвэр, шатахуун	2,992,900.00	2,992,900.00	-	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,558,200.00	261,921.00	2,296,279.00	10.24
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,000,000.00	173,800.00	1,826,200.00	8.69
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,661,700.00	2,621,000.00	(959,300.00)	157.73
Нормативт зардал	100,000.00	100,000.00	-	100.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	100,000.00	100,000.00	-	100.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,968,900.00	1,968,900.00	-	100.00
Урсгал засвар	1,968,900.00	1,968,900.00	-	100.00
Томилолт, зочны зардал	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Дотоод албан томилолт	2,000,000.00	2,000,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	76,872,000.00	76,185,460.00	686,540.00	99.11
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,719,400.00	69,225,460.00	493,940.00	99.29
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,800,000.00	1,800,000.00	-	100.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,100,000.00	1,100,000.00	-	100.00
Газрын төлбөр	1,760,000.00	1,760,000.00	-	100.00
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,492,600.00	2,300,000.00	192,600.00	92.27

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	323,223,200.00	321,670,032.00	-	99.52
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	323,223,200.00	321,670,032.00	2.00	99.52
Улсын төсвөөс санхүүжих	323,223,200.00	321,670,032.00	2.00	99.52
АЖИЛЛАГСАДЫН ТОО	20	20	-	100.00
Удирдах ажилтан	1	1	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	7	7	-	100.00
Үйлчлэх ажилтан	12	12	-	100.00
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	20	20	-	100.00
Соёл урлагийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮСУ)	15	15	-	100.00
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5	5	-	100.00

4.6 Аудит хийгдсэн Нэмэлт төсвийн санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		78,253,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		78,253,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		77,151,654.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		10,599,000.00
Урамшуулал		10,599,000.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,325,000.00
Ажилгүйдлийн даатгал		1,325,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		31,205,500.00
Багаж, техник, хэрэгсэл		8,659,000.00
Тавилга		1,500,000.00
Урсгал засвар		21,046,500.00
Томилолт, зочны зардал		10,351,654.00
Гадаад албан томилолт		10,351,654.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		23,670,500.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		21,230,500.00
Газрын төлбөр		2,440,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		1,000,000.00
Бусад урсгал шилжүүлэг		1,000,000.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		1,000,000.00
Төвлөрүүлэх шилжүүлэг		101,346.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		78,253,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		78,253,000.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		77,253,000.00
Төсвийн урамшуулал		
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

5 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2020.02.12	Аудитын нэр:	2019 оны санхүүгийн аудитын тайлан	Аудитын код:
				САГ-2020/148/СТА-ТШЗ

Шалгагдсан байгууллагын нэр:	Чойжин ламын сүм музейн 2019 оны санхүүгийн тайлангийн аудит	Мянган төгрөгөөр
------------------------------	--	------------------

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Үндсэн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгахгүйгээр 78,151.6 мянган төгрөгийг нэмэлт төсвийн санхүүжилтийн тайланд тусгасан		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
2	Ажил гүйцэтгэх гэрээгээр 3,400.0 мянган төгрөгийн ажлын хөлс олгосныг нийгмийн даатгалын тайланд тусгаагүй, цалин хөлсийг нийгмийн даатгалын тайланд даатгуулагчийн төрлийг буруу ангиллаар 1,029.7 мянган төгрөг тайлагнаснаас нийт 982.8 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн ногдол үүсгээгүй байна.	982.8	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
3	Шатахууны зардлыг тооцохдоо жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, жишиг нормын дагуу тооцоогүйгээс 481.1 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон.	481.1	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
4	Ээлжийн амралтын тооцоог давтан тооцоход 4 ажилтанд 179.6 мянган төгрөгийг илүү олгосон, 11 ажилтанд 1,213.3 мянган төгрөгийг дутуу олгосон.	1,213.3	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
5	Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 67 мэдээллийг хугацаанд нь, 23 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 7 мэдээллийг байршуулаагүй байна.	0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Отгонсүрэн О.Хэрлэн
	Нийт дүн	2,677.2			

